



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/54

Цагаантолгой

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дүгээр заалт, "Мал амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.1, 7.3, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4-9.9, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд мал амьтны гоц халдварт, халдвартөвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, паразиттах өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэхзорилгоор мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хуацаанд эхлэн чанарын өндөр түвшинд зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч - А.Одхүү-(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд-Г.Анхбаяр-(МЭТ-ийн тархвар зүйч)

Л.Сэлэнгэсайхан -(Ивэн 1-р багийн Засаг дарга)

Б.Золбаяр -(Хушаат 2-р багийн Засаг дарга)

О.Лхагвасүрэн- (Сантбаянхайрхан МЭҮН-н Захирал)

Ө.Ганбаатар -(Бошгын булаг ХХК-ны Захирал)

3. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а/ Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчин гарах тархах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мал, амьтны өвчлөл, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, бүртгэх, мэдээлэх, хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэм цуглуулж, устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх

б/ Лабораторийн оношилгоо, шинжилгээ, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтад эрсдэлтэй бүсийн мэдрэмтгий мал, амьтныг технологит хугацаанд бүрэн хамруулах

в/ Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн аж ахуй нэгж байгууллага, иргэд, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авч хариуцлага тооцох

Боловсруулсан: Т. Амгав
Хянасан: С. Шамсудин
Хувь: 2
Огноо: 2022.04.29.

г/ Дархлаажуулах ажлыг ААНБ, малчин, мал бүхий өрхийн мал тооллогод хамрагдсан малыг бүрэн хамруулах ажлыг багийнхаа хэмжээнд зохион байгуулж, зар хүргэн ажиллах

д/ Энэ арга хэмжээний зорилго ач холбогдол хор хохирлын талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулах

е/ Арга хэмжээг товлосон хугацаанд чанартай хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайланг тухай бүрт гарган санхүүжилтийн материалыг бүрдүүлэн сумын Засаг даргаар батлуулж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэх

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Мөнх-эрдэнэ)-д үүрэг болгосугай.

A red rectangular official stamp is located in the center of the page. It contains a handwritten signature in black ink that reads "С.Шижирбаатар". The stamp also contains some faint, illegible text and a checkmark.

С.ШИЖИРБААТАР